

ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРТ
ГАРЫН ҮСЭГ ЗУРСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН
ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхий сайд Чимэдийн Сайханбилэг, Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ бид, өнөөдөр Токио хотноо хэлэлцээ хийж, 3 жил орчим үргэлжилсэн хэлэлцээний дүнд “Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр” /цаашид "хэлэлцээр" гэх/-т гарын үсэг зурсанд баяртай байгаагаа илэрхийлж, дараах Хамтарсан мэдэгдлийг гаргав.

1. Бид, “Эрх чөлөө ба ардчилал, энх тайван, харилцан туслах” хэмээх үзэл санаа нь Монгол Улс, Япон Улсын найрсаг харилцааны үндэс суурь, үнэт зүйлс болж буйг нотлохын хамт, хоёр орны хөгжил болон ард иргэд хоорондын харилцааг улам бүр гүнзгийрүүлэхэд энэхүү хэлэлцээр чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэж, эдийн засгийн хамтын ажиллагаагаар дамжуулан хоёр орны “Стратегийн түншлэл”-ийг бэхжүүлэхэд чухал хувь нэмэртэй болно гэдэгт санал нэгдэв.
2. Бид, энэхүү хэлэлцээр нь хоёр орны хөрөнгө оруулалт, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний урсгал, цаашлаад иргэд хоорондын харилцан солилцоог нэмэгдүүлж, хувь хүн болон хувийн хэвшлийнхэнд бизнесээ тэлэх, хөрөнгө оруулалт хийх шинэ боломжийг бүрдүүлж, улмаар бие биенээ харилцан нөхсөн хоёр орны эдийн засгийн харилцааг шинэ шатанд гаргана гэдэгт санал нэгдэв.
3. Бид, Монгол Улсын хувьд анхны Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болох энэхүү хэлэлцээр нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх, оюуны өмч, өрсөлдөөн, бизнесийн орчинг сайжруулах зэрэг өргөн хүрээг хамарсан, өндөр түвшинд боловсруулагдсаныг онцлон тэмдэглэв.
4. Бид, хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг улам бүр эрчимжүүлэхийн чухлыг онцолж, энэхүү хэлэлцээрийн хамтын ажиллагааны чиглэлийг тус Хамтарсан мэдэгдлийн хавсралтад тусгав.

5. Бид, энэхүү хэлэлцээр нь хоёр орны бүс нутаг болоод олон улсын тавцан дахь эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, улмаар Монгол Улс дэлхийн эдийн засгийн интеграцитай холбогдоход чухал ач холбогдолтой болно гэдэгт санал нэгдэв.
6. Бид, энэхүү хэлэлцээрийг аль болох богино хугацаанд хүчин төгөлдөр болгох чиглэлээр тус тусын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэх эрмэлзэлтэйгээ нотлов.

Токио хот,
2015 оны 2 дугаар сарын 10-ны өдөр

Монгол Улсын Ерөнхий сайд

Япон Улсын Ерөнхий сайд

ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загасны аж ахуй

- Сүү, сүүн бүтээгдэхүүн, үхрийн мах, органик хүнс үйлдвэрлэх;
- Малын эрүүл мэнд болон мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах;
- Загвар фермерийн аж ахуй байгуулах;
- Усжуулалт болон үр тарианы үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Мал, амьтны болон гэрийн тэжээвэр амьтны тэжээл боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Дулаан аргаар мах боловсруулах зэрэг хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Амьтан, ургамлын өвчин эсхүл хортонгоос ангид бүс байгуулах;
- Малын үүлдрийг сайжруулах биотехнологийг хөгжүүлэх;
- Мэргэжилтэн солилцох, техник мэргэжлийн сургалт зохион байгуулах;

2. Аж үйлдвэр

- Аж үйлдвэрийг төрөлжүүлэх;
- Үйлдвэрлэл болон технологийн паркийг хөгжүүлэх;
- Аж үйлдвэрийн салбарын менежмент, өрсөлдөх чадвар, чадавхийг бэхжүүлэх;
- Олон улсын болон дэвшилтэт стандартыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар технологи дамжуулах;

3. Худалдаа ба хөрөнгө оруулалт

- Худалдаа болон хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих,
- Худалдааг хөнгөвчлөх зорилгоор гаалийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих;
- Худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэл (мэдлэгийг түгээх, сайжруулах)–ээр мэргэжилтэн, дадлагажигч, судлаачид солилцохыг дэмжих;

4. Дэд бүтэц, барилга болон хот байгуулалт

- Ухаалаг авто тээврийн систем нэвтрүүлэх, хөгжүүлэх;
- Авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой аюулгүйн стандартыг боловсронгуй болгох;
- Зам, тээврийн хяналт, мониторингийн чадавхийг дээшлүүлэх;
- Хэмнэлттэй эрчим хүчний технологи нэвтрүүлэх;
- Газар хөдлөлтөд тэсвэртэй технологи нэвтрүүлэх;
- Барилгын хатуу хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах технологи нэвтрүүлэх;
- Инженер, техникийн ажилтны мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх;

5. Санхүүгийн үйлчилгээ

- Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх;
- Санхүүгийн үйлчилгээний зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих;
- Банк бус санхүүгийн болон даатгалын үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах;
- Хүний нөөцийн хөгжил, туршлага, ур чадвар солилцох сургалт зохион байгуулах;

6. Боловсрол ба хүний нөөцийн хөгжил

- Ахисан түвшний нарийн мэдлэг, ур чадвар бүхий боловсон хүчнийг бэлтгэх;
- Мэргэжилтэн, эрдэмтэн судлаач болон багш харилцан солилцохыг дэмжих;
- Инженер болон техникийн ажилтанд зориулан техникийн болон техник мэргэжлийн сургалт явуулах;
- Их сургуульд эзэмшсэн боловсрол, эсхүл хуримтлуулсан туршлагыг харилцан хүлээн зөвшөөрөхийг дэмжих;

7. Байгаль орчин

- Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчныг сайжруулах;
- Ус цэвэршүүлэх технологи нэвтрүүлэх;
- Хог хаягдлын менежмент болон түүнтэй холбоотой технологийг сайжруулах;
- Авто тээврийн хэрэгслэлийн хорт хийн ялгаруулалтыг бууруулах;

8. Эрүүл мэнд

- Эрүүл мэнд, шинжлэх ухааны дэвшилтэт технологийг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих;
- Хүний нөөцийг хөгжүүлэх;
- Хамтарсан судалгаа хийхийг дэмжих;
- Эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн солилцох, сургалт зохион байгуулахыг дэмжих;

9. Мэдээлэл, харилцаа холбооны технологи

- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын өрсөлдөх чадвар, технологийн чадавх, менежментыг сайжруулах;
- Нарийн мэдлэг, ур чадвартай боловсон хүчнийг бэлтгэх;
- Хамтарсан судалгаа хийхийг дэмжих;
- Эрдэм шинжилгээний ажилтан, техникийн мэргэжилтэн, шинжээч нарын солилцоог дэмжих.

(Монгол Улс, Япон Улсын Засгийн газар нь энэхүү хэлэлцээр, түүнийг Хэрэгжүүлэх хэлэлцээрийн дагуу аль салбарт ямар чиглэл, хэлбэрээр хамтран ажиллах талаар тухай бүр харилцан зөвшилцөнө.)